

 iridium
САНСРЫН ХОЛБОО

САНСРЫН ХОЛБООНЫ IRIDIUM УТАС АШИГЛАХ ЗААВАР



2222



1800 - 2222 | бусад сүлжээнээс



www.mobicom.mn

IRIDIUM 9575 САНСРЫН ХОЛБООНЫ ГАР УТАС



“IRIDIUM EXTREME” буюу **IRIDIUM 9575** утас өмнөх Iridium 9555 утасны үндсэн бааз дээр хийгдэж, хэд хэдэн функц шинээр нэмэгдсэн. Түүнчлэн Америкийн цэргийн MIL-STD810F ба IP65 стандартад нийцсэн тоос шороо, чичиргээ, доргилт, цохилт, ус борооны битүүмжилсэн давхар хамгаалттай. Iridium 9555 утаснаас 10 % нимгэн, дэлгэцийн гэрэл 7% тод болсон. Мөн Iridium 9505A, 9555 утасны дагалдах хэрэгслүүд тохирно.

ҮНДСЭН ФУНКЦҮУД:

- Яриа
- Текст мессэж
- И-мэйл
- Олон хэлний цэстэй.
- Li Ion батарей: Тасралтгүй ярихад 3.5 цаг, хүлээлтийн горимд 30 цаг ажиллана.
- Ажиллах орчны температур -200C+600C.
- 100 хүртэлх утасны дугаар, и-мэйл, тэмдэглэл хадгалах боломжтой.

ШИНЭЭР НЭМЭГДСЭН ФУНКЦҮУД:

- GPS
- SOS дохио илгээнэ.
- Салхины шуугианаас хамгаалсан чанга яригч, микрофонтой.
- Wi-Fi үүсгэж компьютерт холбогдоно.

“IRIDIUM EXTREME” утсанд шинээр бий болсон 2 гол функц бол **GPS** болон **SOS** юм.


GPS функц

Иридиум 9575 утас болон GPS нь тус тусдаа бие даасан ажиллагаатай. Өөрөөр хэлбэл GPS ажиллахгүй ч иридиум утсаа ашиглаж болно. Харин “Торая”, “ISAT”, “BGAN” төхөөрөмжүүд эхлээд заавал GPS-ээр байршлаа тогтоосны дараа утсаа ашигладаг.

SOS функц

Ямар нэгэн осол аюулын үед SOS функцыг ашиглана. Тодорхой утас руу дохио илгээхээр урьдчилан програмчилдаг. Ослын үед SOS гэсэн товчийг дарахад доорх мэдээллийг 5 минут тутамд програмчилсан дугаар руу илгээнэ. Үүнд:

- Ослын мэдээлэл
- Өргөрөг
- Уртраг
- Далайн төвшинөөс дээшхи өндөр
- Дохио хүлээн авч байгаа GPS-ийн дагуулын тоо
- Он-сар-өдөр ба цаг-минут (GMT-Гринвичийн цагаар)
- Иридиумын батарейны хэмжээ
- Sent via Iridium.



АНУ-д үйлдвэрлэсэн **IRIDIUM 9555** гар утсыг хээрийн хүндрэлтэй нөхцөлд ашиглаж болох чийг, тоос, цохилтноос хамгаалагдсан корпустай. USB портоор дамжуулан интернэтэд 9,6 Кб/сек хурдтай холбогдох боломжтой юм.

ИРИДИУМ 9555 УТАСНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

- 21 хэл бүхий утасны цэстэй.
- 4 мөр, 16 тэмдэгт бүхий монохром шингэн талст дэлгэцтэй.
- Дэлгэцийн гэрэлтүүлэгийг тохируулгатай.
- Цэнэгийн хэмжээг харуулах бөгөөд цэнэг багассан үед дохио өгнө.
- Дуудлага шилжүүлэх буюу хаах боломжтой.
- 10 төрлийн хонх, чичиргээтэй.
- Сүүлийн 10 дуудлага хадгалагдана./call log/
- Хүлээж авсан дуудлагын хугацааг санана.
- Хэмжээ нь Өндөр 143 мм, өргөн 55 мм, зузаан 30 мм, Жин 266г.
- Ажиллах давтамж 1616-1626.5 MHz, L-band.
- Систем TDMA/FDMA.
- Гаралтын чадал 0,645W.
- Ажиллах температур **-10 +55**.
- Батарей 3,7 V, 2800 mAh, Жин 63 г, Тасралтгүй ярихад 4 цаг, Хүлээлтийн горимд 30 цаг.
- Хувьсах гүйдлийн цэнэглэгч 100-240V, 6 V/850 mA.
- Тогтмол гүйдлийн цэнэглэгч 10-32V, 6V/800 mA.
- И-мэйл болон мессэж явуулах, хүлээн авах боломжтой.
- Утас нь чанга яригчтай.
- HELP цэстэй.
- Иж бүрдэл: Утас, батарей, машины цэнэглэгч, хувьсах гүйдлийн цэнэглэгч, машины соронзон суурьтай антен, машины антенний адаптер, чихэвч, утасны гэр.

IRIDIUM 9505A САНСРЫН ХОЛБООНЫ ГАР УТАС

Сансрын Хөдөлгөөнт Холбооны **IRIDIUM 9505A** гар утас нь чийг, тоос, цохилтноос хамгаалагдсан корпустай тул хээрийн хүндрэлтэй нөхцөлд ашиглах боломжтой. Энэ утсаар зөвхөн ярих төдийгүй утасны дугаар нь и-мэйл хаяг болдог тул утас руу болон утаснаасаа и-мэйл бичиж болно.

ИРИДИУМ 9505А УТАСНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

- Иридиум утасны цэс 21-н хэлтэй байдаг.
- 4 мөр, 16 тэмдэгт бүхий монохром шингэн талст (LCD) дэлгэцтэй.
- Дэлгэцийн гэрэлтүүлгийн тохируулгатай.
- Цэнэгийн хэмжээг харуулах бөгөөд багассан үед дохио өгнө.
- Дуудлага шилжүүлэх буюу хаах боломжтой.
- 10 төрлийн хонх, чичиргээтэй.
- Сүүлийн 10 дуудлага хадгалагдана./call log/
- Хүлээж авсан дуудлага, хугацааг санана.
- Хэмжээ нь 158 мм X 62 мм X 59 мм, Жин 375г.
- Ажиллах давтамж 1616-1626.5 MHz, L-band.
- Систем TDMA/FDMA.
- Гаралтын чадал 0,57 W.
- Ажиллах температур **-20 +60** байна.
- Батарей 3,7 V, 2800 mAh, Жин 63г.
- Тасралтгүй ярих 3.6 цаг, хүлээлтийн горимд 30 цаг.
- Хувьсах гүйдлийн цэнэглэгч 100-240V, 6 V/850 mA.
- Тогтмол гүйдлийн цэнэглэгч 10-32V, 6V/800 mA.
- Энэ утасны хоёр төрлийн цэнэглэгчийг сүүлд гарсан бүх загварын утсанд ашиглана.



ИРИДИУМ ГАР УТСАА АЖИЛЛУУЛАХАД БЭЛТГЭХ



- Гар утсаа цэнэглэхдээ доод талд нь “Цэнэглэгч адаптер” эсвэл “Антенний адаптер”-г угсарна. Энэ 2 адаптерыг ашиглан өөрийн цэнэглэгч болон нөүтбүүкээс USB кабелиар цэнэглэж болно. Утсыг 3-4 цаг цэнэглэх ба дэлгэцний баруун дээд буланд байгаа [REDACTED] тэмдэг нь батарейн цэнэгийн хэмжээг заана.
 - Утасны дээд талд байгаа тэжээлийн товчийг 5 секунд орчим дарж асаана.
 - SIM PIN гэж дэлгэцэн дээр гарахад 1111 кодыг хийгээд ОК товчийг дарна.
 - Антенаа дээш сунгаад задгай тэнгэр бүхий газар сонгож ярихад бэлтгэнэ. Антенний үзүүрийн нугардаг хэсэг дээшээ чиглэж байх ёстойг анхаарна уу.
-
- Дэлгэцэн дээр Searching for Iridium гэж гарах ба сүлжээнд холбогдсны дараа Registered гэж гараад дуудлага хийхэд бэлэн болно.
 - Дэлгэцийн зүүн дээд буланд дахь [REDACTED] дүрс нь хиймэл дагуулын сигналын хүчийг илэрхийлнэ. Сигналын хүч бага байвал та байршлаа солих зэргээр сигналын түвшинг ихэсгэх шаардлагатай. Сансрын холбооны гар устыг гадаа задгай орчинд ашиглах зориулалттай тул байшин дотор, өндөр байшингуудын дунд холболт тогтох боломжгүй.
 - Мессэж ирсэн үед [REDACTED] тэмдэг ба **New message. Read now ?** гэж гарна. Унших бол **Yes** гэсэн үгний доор байгаа товчийг дарна.
 - Та урьдчилсан төлбөрт картын хэрэглэгч бол **2888** дугаар руу залгаж англи хэлээр үлдэгдэл нэгж, үйлчилгээний хугацаагаа мэдэж болно. Эсвэл уг дугаар руу хоосон мессэж илгээж, мессэжээр мэдэх боломжтой.
 - Та SingTel-н СИМ карт хэрэглэж байгаа бол **9333** дугаар руу залгаж техникийн зөвлөгөө авах боломжтой.

УТСАА ЗАЛГАХАД ДЭЛГЭЦЭН ДЭЭР ГАРСАН МЭДЭЭЛЭЛИЙН ҮЕД ХИЙХ ҮЙЛДЭЛ

SIM PIN - Сим картны пин код болох 4 оронтой цифрээ оруулна. Шинээр идэвхжих сим картын эхний пин код 1111 байна.

Menu > Security > SIM lock руу орж дараах үйлдлийг хийнэ.

- Enable SIM lock – сим картын пин кодыг идэвхжүүлнэ.
- Disable SIM lock – сим картын пин кодыг идэвхгүй болгоно.
- Phone PIN – утас түгжигдсэн үед утасны пин кодоо оруулна. Утасны эхний пин код 1234 байна.

Menu > Security > Phone lock руу орж дараах үйлдлийг хийнэ.

- Enable Phone lock- Утсаа түгжиж пин кодоо оруулна.
- Disable Phone lock- Утасны түгжээг гаргана.

PIN Blocked - Та пин кодоо 3 удаа буруу оруулж сим картаа блоколсон байна.

Таны утас блоклогдсон үед: **05*(од, од, тэг, тав, од) гэж хийгээд пүк кодоо оруулна уу.

Пүк кодоо мэдэхгүй тохиолдолд албан байгууллага бол тухайн байгууллагыг хариуцсан харилцагч хариуцсан менежертээ, хувь хүн бол Теди төв болон Олимп салбарт хандана.

Blocked, Contact Your Supplier-Та пүк кодоо 10 удаа буруу оруулвал сим карт гэмтэхийг анхаарна уу. Сим карт гэмтсэн тохиолдолд дахин шинээр сэргээж авна.

Check Card -Сим карт гэмтсэн буюу сим картаа буруу хийсэн тохиолдолд гарна.

Insert Card -Утасныхаа тэжээлийг салгаж, сим картаа гүйцэд сайн хийнэ.

Deploy the antenna and make sure it is oriented towards the sky- Энэ үед та антеннаа сунган дээшээ чиглүүлэх, байршлаа өөрчлөх зэргээр сүлжээ орж иртэл хүлээх хэрэгтэй

Menu > Setup > Phone information-г сонгож утасныхаа IMEI кодийг шалгана.

*#06# (Од, чагт, тэг, зургаа, чагт) кодыг ашиглаг сериал кодыг шалгах боломжтой.

Insert Cassete- Таны утас GSM горим дээр байна. “Always satellite mode mode”- руу буцах хэрэгтэй. Үүний түлд **Menu** товч дээр удаан дарж “Mode selection” дээр очин **OK** дараад Always satellite-г сонгож **OK** дарна.

IRIDIUM УТАСНААС ДУУДЛАГА ХИЙХ.

УБ-ын суурин утас руу залгахад: Угтвар дугаар+Улсын код+Хотын код+Суурин утасны дугаар = **00 976 11 312222**

/Улсын код – 976, МЦХК-н сүлжээ – 1, Улаанбаатар хотын код – 1/

Аймаг руу залгахад: Угтвар дугаар+Улсын код+Аймгийн код+Утасны дугаар= **00 976 70 53 7333**

/Улсын код – 976, МЦХК-н сүлжээ – 1, Улаанбаатар хотын код – 1/

Гар утас руу залгахад: Угтвар дугаар+Улсын код+Утасны дугаар = **00 976 99xxxxxx**

Улс хооронд залгахад: Угтвар дугаар+Улсын код+Гар утасны дугаар
Угтвар дугаар+Улсын код+Хотын код+Суурин утас

Иридиум утас руу залгахад: Угтвар дугаар + Утасны дугаар= 00 881631524863 гэх мэт

IRIDIUM УТАС РУУ ДУУДЛАГА ХИЙХ.

МЦХК, Мобиком, Скайтел, Юнител, Жи Мобайлын ГАДААД ЭРХ БҮХИЙ утаснаас Иридиум руу доорх зааврын дагуу залгана.

Иридиум руу залгахад: Олон улсын гарц+Ириудиумын дугаар= **003 881631524863** гэх мэт

- Урьдчилсан болон Хосолсон төлбөрт үйлчилгээний хэрэглэгч дансан дахь нэгжээрээ шууд залгалт хийх боломжтой.
- *Дараа төлбөрт үйлчилгээний хэрэглэгч дугаартаа олон улсын ярианы эрх нээлгэсний дараа залгах эсвэл олон улсын ярианы Глобус карт худалдан авч залгах боломжтой.*

IRIDIUM УТАСНААС МЕССЭЖ, ИМЭЙЛ ИЛГЭЭХ.

Иридиум утас хоорондоо, иридиум утаснаас имэйл хаяг руу, имэйл хаягнаас иридиум утас руу, иридиум утаснаас гар утас руу богино мессэж бичихэд дор дурдсан шаардлагыг хангасан 9505 буюу 9505А утастай байх шаардлагатай.

1. Таны утас 9505, 9505А бол ISO5004 гэсэн хувилбар бүхий програм хангамжтай байх ёстой. Эдгээр програм хангамж байхгүй бол И-мэйл болон SMS явуулах боломжгүй.
2. Өөрийн утасныхаа програмын хувилбарыг шалгахдаа ***#91#** (од, чагт, ес, нэг, чагт)-г дарж шалгана.

Иридиум утаснаас иридиум утас руу мессэж илгээх:

- **Menu > Messages > Create message** цэс рүү орж мессэжээ бичнэ.
- **Option > Send** товчийг дарахад **New Recipient** гэж гарч ирнэ.
- Add товчийг дарж утасны дугаарыг оруулна. + тэмдэг бүхий цонхонд Иридиум утасны дугаараа оруулаад ОК товчийг дарна.

Утасны загвараас хамаран мессэж бичих сонголт өөр өөр харагддаг.

Жишээ нь: 9505A загварын иридиум утас “Message editor” цэс рүү орж текстээ бичээд “ок” дарж “Send message” гэж дэлгэц дээр гарч ирэхэд дахин “ок” дарж “00 эсвэл +” –г оруулсны дараагаар 881xxxxxxx дугаараа оруулан илгээдэг.

Иридиум утаснаас гар утас руу мессэж илгээх:

- **Menu > Messages > Create message** цэс рүү орж мессэжээ бичнэ.
- **Option > Send** товчийг дарахад **New Recipient** гэж гарч ирнэ.
- Add товчийг дарж “+” тэмдэг оруулан улсын дугаарыг оруулж гар утасны дугаарыг бичээд ОК товчийг дарна.

Утасны загвараас хамаран мессэж бичих сонголт өөр өөр харагддаг.

Жишээ нь: 9505A загварын иридиум утас “Message editor” цэс рүү орж текстээ бичээд “ок” дарж “Send message” гэж дэлгэц дээр гарч ирэхэд дахин “ок” дарж “00 эсвэл +” –г оруулсны дараагаар улсын код, гар утасны дугаараа оруулан илгээдэг.

Иридиум утаснаас и-мэйл руу мессэж илгээх:

- **Menu > Messages > Create message** цэс рүү орно.
- Хүлээн авагчийн И-мэйл хаягийг оруулаад нэг зай авч и-мэйл текстээ бичнэ.
- **Option > Send** товчийг дарахад **New Recipient** гэж гарч ирнэ.
- Add товчийг дарж “+” бүхий цонхонд *2 (од, хоёр) гэж бичээд ОК товчийг дарна.

Хэрэв цонхонд “+” тэмдэг байхгүй бол “00”–г оруулна. 00*2 гэж оруулан Send товчийг дарна.

Утасны загвараас хамаран мессэж бичих сонголт өөр өөр харагддаг.

Жишээ нь: 9505A загварын иридиум утас “Message editor” цэс рүү орж текстээ бичээд “ок” дарж “Send message” гэж дэлгэц дээр гарч ирэхэд дахин “ок” дарж “00 эсвэл +” –г оруулсны дараагаар улсын код, гар утасны дугаараа оруулан илгээдэг.

И-мэйл хаягнаас Иридиум руу мессэж илгээх:

- И-мэйл програмынхаа хаяг бичих **то:** гэсэн хэсэгт Иридиумын и-мэйл хаягаа бичнэ. Иридиумын мэйл хаяг нь Иридиумутасныдугаар@msg.iridium.com (881631524863@msg.iridium.com) бүтэцтэй байна.
- Иридиум утас руу attach-тай и-мэйл илгээж болохгүй.
- И-мэйлийн Subject мөрөн дээр бичсэн үг Иридиум рүү очихгүй тул бичих шаардлагагүй.
- Иридиум утсан дээр и-мэйл ирсэн үед New SMS. Read Now? гэсэн үг гарна.

Интернэтээс иридиум утас руу мессэж илгээх:

- <http://www.iridium.com/> сайт руу орно.
- Send a Satellite message гэсэн линкийг сонгоно.
- To: гэсэн хэсэгт Иридиум утасныхаа дугаарыг бичнэ.
- Reply email хэсэгт хариу хүлээн авах и-мэйл хаягаа оруулна.
- Мессэжээ бичээд Send Message товчийг дарна.

IRIDIUM УТАСНЫ GPS АШИГЛАХ.

Иридиум утаснаас гар утас руу мессэж илгээх:

- Menu > Setup > Location Options > GPS Option > GPS On/Off > Enabled болгож GPS-ээ ажиллуулахад бэлэн болгоно.
- Menu > Setup > Location Options > GPS Option > GPS Update Option GPS-ийн дагуулын сигнал хүлээж авах интервалаа сонгоно.
- Menu > Setup > Location Options > GPS Option > GPS Settings Lock GPS-ээ PIN кодоор нээдэг болгохыг хүсвэл Enabled болгоно.
- Convenience Key (Нэмэлт товч)-ийг дарж өөрийн байгаа газрынхаа координатыг тодорхойлно.

Иридиум утасны SOS функцыг ашиглах:

Иридиум утасны шинэ функц болох SOS нь хэрэглэгч осолд орсон үед урьдчилан програмчилсан дугаар руу уг дохиог илгээх боломжтой юм. Утсан дээр байгаа улаан товчийг дарахад доорх мэдээлэлийг програмчилсан дугаар руу 5 минут тутам илгээнэ.

- Ослын мэдээлэл
- Өргөрөг
- Уртраг
- Далайн төвшинөөс дээшхи өндөр
- Дохио хүлээн авч байгаа GPS-ийн дагуулын тоо
- Он-сар-өдөр ба цаг-минут (GMT-Гринвичийн цагаар)
- Иридиумын батарейны хэмжээ (Процентоор)
- Sent via Iridium

Иридиум утасны SOS функцийг програмчлах:

SOS нь хэрэглэгч ямар нэгэн осолд орсон тохиолдолд урьдчилан програмчилсан утас руу ослын мэдээлэл бүхий дохио илгээх боломж бүхий функц.

- Menu > Setup > Location Options > Emergency Options руу орж тохиргоог хийнэ.
- Emergency Actions – Ослын дохиог ямар төрлөөр хүлээж авахаа сонгоно. Үүнд:
 - Message and Call Мессэж ба Дуудлагаар
 - Message only Зөвхөн мессэжээр
 - Call only Зөвхөн дуудлагаар
- Message Recipient Ослын дохиог мессэжээр хүлээж авах утасны дугаараа оруулна.
- Call Recipient Ослын дохиог дуудлагаар хүлээж авах утасны дугаараа оруулна.

IRIDIUM УТАСНЫ GPS АШИГЛАХ.

SOS функцын гэрлийн диод (SOS indicator LED)

- Улаан өнгөөр анивчих- Байршилаа (координатаа) тодорхойлж байна.
- Улбар шар өнгөөр анивчих- Байршилын мэдээлэл явуулж байна.
- Шар өнгөөр анивчих- Байршилын мэдээлэлээ явууллаа.
- Ногоон өнгөөр анивчих- Дараагийн мэдээлэл явуулахаар бэлтгэж байна.

Иридиум утсаа RESET хийх:

- Утсаа асаана. MENU-г сонгоно.
- Гүйлгэгч товчоор SETUP-ийг сонгоно..
- Гүйлгэгч товчоор Reset to defaults-г сонгоно.
- Reset all phone setting гэсэн үг гарахад Yes-г сонгоно.

 iridium

САНСРЫН ХОЛБОО

